



БРОКЕР, ДИЛЕРИЙН
КОМПАНИУДАД

ХӨСӨГ ТРЕЙД

Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
29-р хороо, Эрчим хүчний гудамж,
“Хөсөг Трейд” ХК өөрийн байр.

2025.03.10 № 15/15

Танай _____ -ны № _____ Т

Баримт бичиг хүргүүлэх тухай

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.10-д “Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлнэ” хэмээн заасан байдаг.

“Хөсөг трейд” ХК нь 2025 оны 04 сарын 14-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах гэж байгаатай холбогдуулан хавсралтаар холбогдох баримт, бичгийг хүргүүлж байна.

Иймд хавсралтаар хүргүүлж буй баримт бичгийг манай компанийн хувьцаа эзэмшигчдэд танилцуулах ажиллагаанд хамтран ажиллаж тусална уу.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ЭРДЭНЭСҮХ



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сар 28 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1 дахь заалтууд, 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэл, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 11 цаг 00 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сэнтрал тауэр 902 тоот хурлын танхимд хуралдуулахаар тогтоож компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
 - Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 03 сарын 24-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан 2025 оны 03 дугаар сарын 06-ний өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2025 оны 03 сарын 21-ны өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Анхбаяр/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг брокер, дилерийн компаниудаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 2-т зааснаар баталсугай.
7. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 17.30 цагаар тасалбар болгосугай.
8. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах болон тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:
 - С.Болор Хурлын дарга

- Б.Анхбаяр Хурал зохион байгуулах комиссын дарга
- Б.Гэрэлмаа Тооллогын комиссын дарга
- Б.Энхтүвшин Гишүүн

9. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс-д даалгасугай.
10. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг Хавсралт 3-аар баталсугай
11. Хурлын дэгийг Хавсралт 4-өөр баталсугай.
12. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт 5-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Анхбаяр/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.БОЛОР




*“Хөсөг трейд” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 03 тоот
тогтоолын Хавсралт №01*

**“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан тогтоол;
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай тогтоол болон хавсралтууд;
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудасны загвар;
- Ээлжит хурал зарласантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл.

“Хөсөг трейд” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 03 тоот
тогтоолын Хавсралт №02



“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 11.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сентрал тауэр 902 тоот Хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд / овогтой
Төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар:

Регистрийн дугаар:

Гэрийн хаяг:

Эзэмшиж буй хувьцааны төрөл:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Кумулятив аргаар өгөх саналын тоо:

Бүртгэсэн: /Үнэт цаасны компанийн нэр/

Брокерын овог.....нэр.....

№	Хурлаас гарах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг..... / /

Санал авахыг хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан

.....

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга / /

Гишүүн..... / /

Шалгаж хүлээн авсан БДК-ийн ажилтан..... / /

“Хөсөг трейд” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 03 тоот
тогтоолын Хавсралт №03



“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 11.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сэнтрал тауэр, 902 тоот хурлын танхимд хуралдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ:


- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг Брокер, дилерийн компани дээр ажлын өдрүүдэд (Даваа-Баасан) 9:00 цагаас 16:00 цаг хүртэл авах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Анхбаяр болон гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас: 99029407, 89035757

Имэйл хаяг: ankhaa4142@gmail.com

“Хөсөг трейд” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 03 тоот
тогтоолын Хавсралт №04




“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 11:00 цагт эхэлнэ.

	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцан танилцуулагч
1	Хурлын ирцийг бүртгэх	11:00-11:20	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг хурлын дарга болон хуралд оролцогч нарт мэдээлэх	11:20-11:30	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	11:30-11:50	Хурлын дарга
4	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах	11:50-12:10	Хурлын дарга
5	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах	12:10-12:25	Хурлын дарга
6	Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах	12:25-12:30	Хурлын дарга
7	Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт	12:30-12:45	Хурлын дарга
8	Саналын хуудас бөглөх заавар танилцуулах	12:45-13:00	Тооллогын комисс
9	Саналын хуудсаар санал авах	13:00-13:15	Тооллогын комисс
10	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах	13:15-13:25	Тооллогын комисс
11	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	13:25-13:35	Хурлын дарга
12	Хурлыг хаах	13:35-13:40	Хурлын дарга

“Хөсөг трейд” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 03 тоот
тогтоолын Хавсралт №05



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“ХӨСӨГ ТРЕЙД” ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, Гурвалжингийн гүүр, компанийн өөрийн байр
Хурал хуралдах өдөр, цаг:	2025.04.14-ний 11 цаг 00 минут
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, Сэнтрал тауэр 902 тоот. Хурлын танхим. 89035757
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2025.02.28
Олон нийтэд зарлах огноо:	2025.03.06, 2025.03.21
Бүртгэлийн өдөр:	2025.03.24
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2025.03.10
Хүргүүлсэн огноо:	2025.02.28
Хурлын дарга нэр:	С.Болор
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга Б.Гэрэлмаа, гишүүд Б.Энхтүвшин
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Гуз-и тогтоол, хавсралтууд, Гуз-и тэмдэглэл
Баримт бичгийн хуудасны тоо:2.....ширхэг11.....хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА /Б.АНХБАЯР/

2025 оны 02 дугаар сарын 28-ний өдөр



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сар 14 өдөр

№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Компанийн 2024 оны санхүүгийн тайлантай холбогдуулан цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

Хоёр. 2025 онд компанийн үйл ажиллагааг эрчимжүүлж, илүү үр ашигтай ажиллуулах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулахад идэвх санаачилга гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д даалгасугай.

Гурав. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн талаарх мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Анхбаяр/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.БОЛОР



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сар 28 өдөр

№ 01

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

Хөсөг трейд ХК нь өөрийн өмчлөлийн барилга байгууламж, эзэмшлийн газраа бусдад түрээсэлж түүнээс олсон орлогоороо урсгал зардлаа санхүүжүүлэх байдлаар үйл ажиллагаагаа эрхэлж байсан бөгөөд барилга байгууламж болон түүний орчин тойрны тохижилтыг сайжруулах засварын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж чадахгүй байсны улмаас хөрөнгийн биет байдалд материаллаг доголдол үүсэх эрсдэл бий болоод байсан бол 2022 онд стратегийн хөрөнгө оруулагчтай урт хугацааны хамтын ажиллагаа эхлүүлснээр шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж засвар, бүтээн байгуулалтын ажлыг өргөн хүрээнд эхлүүлсэн.

2023 онд хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхээр төмөр замын бүтээн байгуулалт, төвийн нэгдсэн уур, ус, дулаан, бохир, цахилгааны шугам сүлжээ татах, холбох зэрэг шаардлагатай дэд бүтцийн бүтээн байгуулалтыг ажлыг амжилттай хийж дууссан.

Мөн Хөсөг Трейд ХК-ийн барилга байгууламжийг засварлах, сэргээн босгохоор ажил эрчимтэй үргэлжилж байгаа бөгөөд 2024 оны 3 дугаар улиралд эхний хэсэг болох оффисын зориулалттай барилгын засварыг ажлыг дуусган ашиглалтад хүлээн авсан.

Бүтээн байгуулалтын ажлыг чанартай гүйцэтгэх, хөрөнгийн биет байдал, өгөөжийг нэмэгдүүлэхээр компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын баг хичээн ажиллах болно. Ингэснээр урт хугацаанд хувьцаа эзэмшигч нарын хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Тайлант хугацаанд Хөсөг Трейд ХК-ийн үйл ажиллагаа орлого 718.8 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 409.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байсан. Үйл ажиллагааны зардлын 52 хувь нь ашиглалтын зардал, 30 хувь нь элэгдлийн зардал, 18 хувь нь хөрөнгийн болон газрын татвар хураамжийн зардал тус тус эзэлсэн.

Бүтээн байгуулалтыг 2025 оны 3 дугаар улиралд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж, ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.БОЛОР

Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх
төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан
дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46.6 болон 62.1.9 дэх заалт, “**ХӨСӨГ
ТРЕЙД**” ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компани 2024 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн
төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцуулсныг дурдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах
зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.БОЛОР